

ГАДААД БОДЛОГЫН ШИЙДВЭРИЙН ОНОЛ: ГЭЛЛИСОНЫ ГУРВАН ЗАГВАРТ ХИЙСЭН ҮНЭЛЭЛТ, ДҮГНЭЛТ

П.Мягмардорж*

Abstract: *In this article, the author aimed to give the audience a comprehensive overview of the theoretical approaches to Foreign policy decision making and evaluate Graham T. Allison's three models of foreign policy analysis. Not only the paper explains what these models are for, but it also includes the comparative study of three models. Allison developed three different models of decision-making in foreign policy. Study of foreign policy with the help of these proposed models; on the same question, one can get different answers. It can be stated that Allison is "often praised for his realistic and intuitively attractive description" by all foreign political analysts as well as political activists and leaders. However, scholars have also criticized his model for "its complexity and lack of explanatory power." These three models are based on different levels of analysis, and one must use all of them to get a complete interpretation of any political decision making case. Each model should be understood as a picture that fixes only part of the overall complex picture.*

Key words: *Graham Allison, Rational Actor Model, Organizational Behavior Model, Bureaucratic Politics Model*

Оршил: “Гадаад бодлогын шийдвэр гаргалт гэдэг нь олон улсын харилцааны үндсэн оролцогч болох улс үндэстний гадаад үйл ажиллагаанд нөлөөлж буй хувь хүмүүс, бүлэг ба эвслүүдийн сонголтууд юм” гэж гадаад бодлогын шийдвэр гаргалтын онолын нэр хүнд бүхий судлаачид болох Алекс Минц, Карл ДеРуизен нар “Гадаад бодлогын шийдвэр гаргалтыг ойлгохуй” хэмээх бүтээлдээ тодорхойлжээ.² Гадаад бодлогын шийдвэр нь гол төлөв урьдчилан таамаглахад төвөгтэй, ихээхэн эрсдэл бүхий, өндөр бооцоо шаардаж байдаг үйл ажиллагааны үр дүн хэмээн тооцогддог.³ Гадаад бодлогын шийдвэр гаргалт нь олон улсын харилцааны онолын судалгааны нэгэн чухал салбар учир түүний мөн чанар, бүтцийг ойлгох нь өндөр ач холбогдолтой. Олон улсын харилцааны түүхээс

* ХИС-ийн Олон улс, нийгэм судлалын тэнхмийн ахлах багш, доктор (Ph.D.)
Цахим хаяг: myagmardorj@humanities.mn

² Alex Mintz and Karl DeRouen. “Understanding Foreign Policy Decision Making”. New York: Cambridge University Press, 2010, p.3.

³ J.Renshon, S.A.Renshon. “The Theory and Practice of Foreign Policy Decision Making”. Political Psychology, Vol. 29 No. 4, 2008, p.509

харахад улс гүрнүүдийн удирдагчдын гадаад бодлогын асуудлаар гаргаж байсан шийдвэр нь дэлхийн улс төрийн бодлогын хувь заяаг тодорхойлж ирсэн төдийгүй цаашид ч тодорхойлох нь ойлгомжтой тул шийдвэр гаргах үйл явцыг судлах нь зайлшгүй. Гадаад бодлогын шийдвэр гаргах үйл явц нь шатрын нүүдэлтэй тун төстэй оролцогчдын үндэсний ашиг сонирхолоо хамгаалах зорилгоор явуулж буй үйл ажиллагаа, шийдвэрээс хамаарч байдаг тул улс орнууд гадаад бодлогын шийдвэрээ алдаа мадаг багатайгаар гаргах замаар ашиг сонирхолоо дээд зэргээр нэмэгдүүлэхийг байнга эрмэлздэг.

Гадаад бодлогын шийдвэр гаргалтад янз бүрийн институциуд, төрийн болон төрийн бус байгууллагын олон тооны тоглогчид нөлөөлөн оролцдог хэдий ч эцсийн шийдвэрийг улс гүрний удирдлагын дээд түвшинд гаргадаг. Шийдвэр гаргалтад оролцдог гол тоглогчдын бодит хямралыг урьдчилан тооцоолох ур чадвар, даван туулах туршлага, нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх чадвар, хүнд хэцүү үед үл шантрах хандлага, хамгийн гол нь онол практикийн танин мэдэхүйн чадавх нь улс орны гадаад бодлогын үр дагаварыг тодорхойлж байдаг төдийгүй дэлхийн улс төрийн нөхцөл байдлыг ч өөрчлөх боломжтой.⁴ Улс гүрний гадаад бодлогын шийдвэр гаргагчид таамаглахын аргагүй нөхцөл байдлыг урьдчилан тооцоолж, үндэсний ашиг сонирхолд нийцсэн зөв шийдвэр гаргах чадвартай байх ёстой. Ялангуяа асар хурдан өөрчлөгдөж байгаа өнөөгийн олон улсын харилцааны системийн онцлогийг харгалзан шийдвэр гаргах механизмыг зөв зохистой зохион байгуулан үр дүнтэй шийдвэр гаргахад анхаарах шаардлагатай болоод байна.

Иймд гадаад бодлогын шийдвэр гаргалтын онолын судалгаанд тэргүүлэх байр суурь эзлэдэг АНУ-ын эрдэмтэн Грэхэм Эллисоны шийдвэр гаргалтын сонгодог гурван загварыг судлан, тус бүрт нь үнэлэлт өгч Монгол улсын гадаад бодлогын шийдвэр гаргах үйл явцад аль загвар нь илүү тохиромжтой талаар дүгнэлт хийх нь энэхүү судалгааны өгүүллийн үндсэн зорилго юм.

Г.Эллисоны гадаад бодлогын шийдвэр гаргалтын гурван загварт хийсэн үнэлгээ

Гадаад бодлогын шийдвэр гаргалт нь байнга өөрчлөгдөж байдаг нарийн төвөгтэй үйл явц юм. Гадаад бодлогын шийдвэр гаргах үйл явц нь дотоод болон гадаад, улс төр болон нийгэм эдийн засаг, засаглалын хэлбэр болон засгийн газрын бүтэц, шийдвэр гаргагчдын эрх мэдлийн хэмжээ, ард олны үзэл санаа, шийдвэр гаргагчийн хувийн зан араншин гэх мэт олон хүчин зүйлээс хамаарч байдаг. Гадаад бодлогын шийдвэр гаргалтын энэхүү адармаатай асуудлыг шийдвэрлэх зорилгоор олон судлаачид шийдвэр гаргалтын тогтсон онолын загварыг боловсруулах оролдлогыг удаа дараа хийж байсны дотор Харвардын их сургуулийн профессор Грэхэм Т.Эллисон, Виржиниагийн Их Сургуулийн

⁴ Sibaram Badatya, "Parliament and Foreign Policy Decision Making in India: A Study on India's China Policy 1959-75" (PhD diss., Pondicherry University, 2015), p.37

профессор Филип Зеликов нарын дэвшүүлсэн гадаад бодлогын шийдвэр гаргалтын онолын загвар нийтэд түгээмэл болж чадсан билээ. Тэд Карибын хямралын жишээн дээр онолын загвараа боловсруулсан бөгөөд 1971 онд бичиж хэвлүүлсэн *“Шийдвэр гаргалтын мөн чанар”* хэмээх бүтээлдээ гадаад бодлогын шийдвэр гаргалтын гурван загварыг танилцуулсан байна.⁵ Эдгээр загвар нь: *“Оновчтой тоглогчийн загвар”*, *“Зохион байгууллалттай үйл явцын загвар”*, *“Бюрократ буюу засгийн газрын бодлогын загвар”* зэрэг болно⁶.

Оновчтой тоглогчийн загвар: “Оновчтой тоглогчийн загвар” гэдэг нь шийдвэр гаргаж буй удирдагч гадны ямар нэгэн нөлөөнд авталгүй шаардлагатай гэж үзсэн шийдвэрээ гаргадаг загвар юм.⁷ Энэхүү загварын дагуу, шийдвэр гаргагч нөхцөл байдлыг үнэлж, гадаад бодлогын олон янзын шийдвэрүүдээс хамгийн **оновчтой загварыг сонгодог** байна. Энэ загварыг боловсруулсан Грэхэм Эллисоны үзэж буйгаар *“оновчтой байдал” гэдэг нь хязгаарлагдмал байдлын хүрээнд боломжит сонголтыг хамгийн их байлгах явдал юм.*⁸ Үүнээс гадна *“оновчтой тоглогч буюу шийдвэр гаргагч нь сонголтуудыг зөв тодорхойлох чадвартай байхын сацуу эдгээр сонголтуудаас хамгийн үр ашигтайг сонгох чадвартай байдаг”.*⁹ Иймээс “Оновчтой тоглогчийн загвар” гэдэг нь үндэсний ашиг сонирхолыг хангахын тулд гадаад бодлогын олон шийдвэрүүд, тэдгээрийн үр дагаварыг тооцох замаар эцсийн шийдвэрийг гаргах үйл явц бөгөөд нэг үгээр хэлбэл оновчтой шийдвэр гаргах гэдэг нь үр дүнг тооцох чадвар юм.¹⁰ Үнэн хэрэгтээ энэ загвар нь **“зорилгодоо хэрхэн үр ашигтайгаар хүрэх вэ?”** хэмээх асуултад хариулахыг оролддог. Энэ загварын дагуу шийдвэр гаргаж буй институт буюу засгийн газар нь нэгдмэл нэг оновчтой бүтэц бүхий байх бөгөөд тиймээс энэ загварыг реалист хэмээн тодорхойлох нь бий.¹¹ Гадаад бодлогын шийдвэр гаргалтын оновчтой тоглогчийн загвар нь дараахь 7 шатлалаар хэрэгждэг талаар Грэхэм Эллисон өөрийн бүтээлдээ дурьджээ. Эдгээр нь:

1. Шийдвэр гаргалтад тулгамдаж буй асуудлыг тодруулах
2. Асуудлыг задлан шинжлэх
3. Шийдвэр гаргалтын тэргүүлэх зорилгоо тодорхойлох
4. Шийдвэр гаргалтын олон янзын хувилбаруудыг боловсруулах
5. Хувилбар тус бүрээр үнэлгээ хийх

⁵ Graham Allison, Philip Zelikow. “Essence of Decision: Explaining the Cuban Missile Crisis”. Second Edition, New York: Longman, 1999, pp.4-5.

⁶ “Rational Actor Model”, “Organizational Behavior Model”, “Bureaucratic Politics Model” (“Governmental politics model” хэмээн бас нэрлэдэг) гэдгийг ийнхүү хөрвүүллээ.

⁷ Sibaram Badatya, “Parliament and Foreign Policy Decision Making in India: A Study on India’s China Policy 1959-75” (PhD diss., Pondicherry University, 2015), p.38.

⁸ Graham Allison, Philip Zelikow. “Essence of Decision: Explaining the Cuban Missile Crisis”. Second Edition, New York: Longman, 1999, p.18.

⁹ Alex Mintz and Karl DeRouen. “Understanding Foreign Policy Decision Making”. New York: Cambridge University Press, 2010, p.57

¹⁰ W. Raymond Duncan, Barbara Jancar-Webster, Bob Switky, World Politics in the 21st Century (Boston: Cengage Learning, 2009) pp.130-158

¹¹ Efe Yegul, “US Foreign Policy Decision Making Process and Key Actors” University of Warsaw paper, https://www.academia.edu/36624180/US_Foreign_Policy_Decision-Making_Process_and_Key_Actors

6. Хамгийн оновчтой хувилбарыг сонгох
7. Шийдвэр гаргах¹² зэрэг болно.

Канадын эрдэмтэн, улс төр ба олон улсын харилцааны судлаач Жэнайс Штайны бичсэнээр “*оновчтой тоглогчийн загвар гэдэг нь шийдвэр гаргагчийн сонголт хийх үйл явц бөгөөд шийдвэр гаргагч энэ тохиолдолд логик сэтгэлгээтэй, дүрэм журмыг сайтар мөрддөг байх шаардлагатай*”.¹³ Иймээс энэхүү загварын хүрээнд шийдвэр гаргалт нь логик гаргалгаа сайтай, бодитой, ямар нэгэн айдаст авталгүй, хувийн ашиг хонжоо харалгүйгээр хийгдсэн байх ёстой болж байна. Гэхдээ “оновчтой” хэмээх ойлголтыг яг таг тодорхойлоход ярвигтай бөгөөд энэ загвар нь ямар нэгэн тогтсон хэм хэмжээ, стандартад баригдах боломжгүй юм. Учир нь шийдвэр гаргагчийн хувийн чанар, засгийн газрын бүтэц зохион байгуулалт, тухайн олон улсын харилцааны нөхцөл байдал ялгаатай байдаг тул оновчтой байдлаар шийдвэр гаргах гэдгийг загварчилахад тун төвөгтэй юм. Нэг удирдагчид оновчтой зөв санагдсан шийдвэр нөгөө удирдагчид оновчгүй шийдвэр байх жишээтэй. Ийм жишээг олон улсын харилцааны түүхээс олонтаа харж болно. Энэхүү загварын шүүмжлэлд өртдөг бас нэг зүйл нь шийдвэр гаргагчдын хувийн зан төлөв, сэтгэл хөдлөл, хүсэл тэмүүллийг тооцож үздэггүйд байна.

Зохион байгуулалттай үйл явцын загвар: Даяаршлын үед гадаад бодлогын шийдвэр гаргах үйл явц нь өнгөрсөн үеийнхээс илүү адармаатай болж байна. Учир нь өнөөгийн олон улсын харилцааны хэлбэр маш их ихээр төрөлжиж байгаа төдийгүй олон улсын харилцаанд асар их нөлөөтэй шинэ оролцогчид олноор гарч ирж, сонгодог оролцогч буюу улс оролцогч, түүний засгийн газрын шийдвэр гаргалтад нөлөөлөх чадавхитай дотоод, гадаадын хүчтэй тоглогчид олноор бий болж байна. Үүний сацуу аливаа улсын гадаад бодлогын шийдвэр гаргалт нь олон хүчин зүйлээс хамаарсан, олон түвшний үйл явц болон хувирч байна. Ийм нөхцөлд үр дүнтэй, сайтар боловсруулагдсан, олон шатны ашиг сонирхолыг тусгасан, засгийн газрын шийдвэрийн нэгдмэл байдлыг хангаж чадахуйц гадаад бодлогын шийдвэр гаргалтын загвар хэрэгтэй. Энэхүү асуудлыг шийдвэрлэх зорилгоор Грэхэм Эллисон “зохион байгуулалттай үйл явцын загвар”-ыг санал болгожээ.

“Зохион байгуулалттай үйл явцын загвар” гэдэг нь засгийн газрын төрөл бүрийн байгууллагын олон түвшний үйл ажиллагааны үр дүнд шийдвэр гаргах явдал юм. Хоорондоо үйл ажиллагаа нь холбогддог засгийн газрын олон тооны салбар байгууллагаас гарч буй шийдвэрүүдийг нэгдмэл байдлаар, уялдаа холбоо сайтай, тогтсон дүрэм журмын дагуу гаргах явдал нь энэ загварын гол онцлог юм. Шийдвэр гаргахын өмнө засгийн газрын тодорхой байгууллагуудад гүйцэтгэх ажил, үүрэг даалгаврыг чиглэл, чиглэлээр нь хувиарлах замаар зохион

¹² Graham Allison, Philip Zelikow. “Essence of Decision: Explaining the Cuban Missile Crisis”. Second Edition, New York: Longman, 1999, p. 58.

¹³ Janice Gross Stein. “Foreign Policy Decision-Making: Rational, Psychological, and Neurological Models”, in Foreign Policy: Theories, Actors, Cases”. Edited by Steve Smith, Amelia Hadfield and Tim Dunne. Oxford: Oxford University Press, 2008. p.102

байгуулдаг. Эдгээр байгууллага, нэгжүүд тус тусын хариуцсан үүрэг даалгаврыг богино хугацаанд гүйцэтгэн, эцэст нь үр дүнг нь нэгтгэн боловсруулах бөгөөд нэн яаралтай шийдвэр гаргах шаардлага тулгарсан үед ихэвчлэн эхний бэлэн болсон хувилбарыг авч үздэг. Энэ загвар нь хямралын нөхцөлд хамгийн хялбар, хурдан шийдвэрийг гаргаж болдогоороо давуу талтай.

Г.Эллисоны энэхүү загварын дагуу шийдвэр гаргагчийн оновчтой шийдвэрээр бус тогтсон загвар бүхий тодорхой зохион байгуулалттайгаар хийгддэг хэлэлцүүлгийн үр дүнд улс төрийн шийдвэр гардаг. *“Дайн яагаад үүсдэг вэ?”* номын зохиогч Грег Кэшмэнний бичсэнээр *“Засгийн газар нь тус тусдаа үйл ажиллагаа явуулдаг бие даасан, өөрийн гэсэн шийдвэр гаргах эрх мэдэл бүхий байгууллагуудын үйл ажиллагаа, гарсан шийдвэрүүдийг нэгтгэх үүрэгтэй байгууллага юм”*.¹⁴ Ийм учир засгийн газрын түвшинд шийдвэр гаргахдаа тухайн засгийн газрын бүтцэд багтдаг олон тооны салбар байгууллагуудын үйл ажиллагаа, гарч буй шийдвэрүүдийг сайтар уялдуулах шаардлагатай. Английн философич Мартин Холлис, олон улсын харилцааны онолын судлаач Стив Смит нарын үзсэнээр “зохион байгуулалттай үйл явцын загвар”-ын дагуу засгийн газрын нэгж, агентлагууд нь шийдвэр гаргагч дээд удирдлагуудын хэрэгцээ шаардлагад нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулдаг байна.¹⁵

Г.Эллисоны хоёр дахь загвар буюу “зохион байгуулалттай үйл явцын загвар” нь байгууллагын менежментийн онолоос санаа авсан бөгөөд уг загварын дагуу шийдвэр гаргах бүтэц нь хэд хэдэн дэд бүтцэд хуваагдана. Шийдвэр гаргагч дээд удирдлага нь шийдвэр гаргалтад тулгамдаж буй асуудлыг хэд хэдэн хэсэгт хуваан өөрийн бүтцэд багтаж буй салбар буюу дэд хэсгүүдэд хүргүүлдэг. Эдгээр салбар байгууллагууд нь тогтоосон хугацааны дотор тухайн асуудлаа шийдвэрлэх шаардлагатай. Цаг хугацаа давчуу, хямралын үед дээд түвшний удирдлага доороос боловсруулагдан ирсэн саналуудаас хамгийн оновчтойг нь гэхээс илүү хамгийн эхний бэлэн болсон хувилбарыг сонгон шийдвэр гаргадаг. Гадаад бодлогын шийдвэр гаргалтад нөлөөлж өөр өөрсдийн ашиг сонирхолыг гүйцэлдүүлэх сонирхолтой янз бүрийн тоглогчдын ашиг сонирхолыг нэгтгэх шаардлага гардаг тул энэ загвараар гарч буй шийдвэр нь **“оновчтой” гэхээс илүүтэй “сэтгэл ханамжид нийцсэн”** байдаг. “Зохион байгуулалттай үйл явцын загвар” нь дээд түвшинд яаралтай шийдвэр гаргах шаардлага тулгардаг хямралын болон дайны үед илүү зохимжтой. Энэ загвар бол хамтын хариуцлага ба нийтлэг зорилго, зарчим дээр суурилдаг.

Грег Кэшмэн энэхүү загварын үндсэн онцлогуудыг дараах байдлаар жагсаасан байна. Үүнд:

- “Зохион байгуулалттай үйл явцын загвар”-ын дагуу гарч буй шийдвэр нь

¹⁴ Greg Cashman, “What Causes War? An Introduction to the International Conflict”.Lanham, Maryland: Laxington Books, 2000. p.86

¹⁵ Martin Hollis and Steve Smith. “Explaining and Understanding International Relations”.Oxford: Clarendon Press, 1990. 8-9, pp.196-202

оновчтой гэхээс илүү сэтгэл ханамжид нийцсэн байдлаар гардаг.

- Энэ загвар нь ямагт инкрементализм буюу доороос дээшээ гэсэн зарчимд суурилдаг тул шийдвэр гаргалт нь ихээхэн эерэг, байнгын үргэлжилж байдаг үйл явц болж байдаг.
- Шийдвэр гаргалтын энэ загвар нь нэлээд хатуу стандартыг дагаж мөрдөх шаардлагатай бөгөөд уян хатан шинж байдлыг агуулаагүй болно.
- Энэ загварын дагуу шийдвэр гаргахад дээд удирдлагын цөөн тооны шийдвэр гаргагчдын туршлага, мэдлэг ур чадварыг бус мэргэжлийн туршлагатай судлаач шинжээч болон бусад байгууллага, бодлогын судалгааны хүрээлэнгүүдийн судалгааны үр дүнг чухалчилж үздэг.
- Эцэст нь дээд түвшний шийдвэр гаргагч уг загварын дагуу шийдвэр гаргалтын олон янзын хувилбаруудаас сонголт хийхдээ оновчтойг бус хамгийн эхний хувилбарыг сонгодог зэрэг болно.¹⁶

“Зохион байгуулалттай үйл явцын загвар” нь гадаад бодлогын шийдвэр гаргалтын онолд олон талын эерэг өөрчлөлт оруулсан байдаг. Менежментийн онолын нөлөөгөөр энэ загвар нь хэд хэдэн дэд хэсгүүд буюу салбар байгууллагуудыг шийдвэр гаргах үйл явцад татан оролцуулдаг учир Г.Эллисон энэхүү хоёр дахь загварыг ихэд чухалчилж байсан юм. Хэдий тийм боловч энэ загвар нь бусад загварын нэгэн адил хэд хэдэн сул талтай болох талаар судлаачид шүүмжлэн бичсэн байдаг. Үүнд:

- “Зохион байгуулалттай үйл явцын загвар”-ын дагуу гарч буй шийдвэр нь шийдвэр гаргалтад оролцож буй янз бүрийн олон тооны оролцогчдын мэдрэмж, хүсэл эрмэлзэл, ашиг сонирголоор тодорхойлогдож байдаг тул “оновчтой”, үр дүнтэй байх магадлал бага.
- Шийдвэр гаргалтын үйл явцад оролцож буй оролцогчийн хувийн чадавх нь тогтсон загвар стандартаар хязгаарлагдаж байдаг тул шийдвэр гаргалтын уян хатан шинж чанар алдагддаг. Иймд үр дагавар нь гол төлөв сэтгэл ханамжид тулгуурласан байхаас бус ашиг хонжоог дээд түвшинд байлгаж чадахгүй сул талтай.
- Шийдвэр гаргалтын бүтцэд багтдаг салбар, дэд байгууллага тус бүр өөр өөрсдийн зэрэг зиндаа, үнэт зүйл, зорилго, зорилгодоо хүрэх арга хэрэгсэлтэй. Тиймээс салбар бүрийн зорилго нь нийтлэг зорилготой давхцахгүй байх боломжтой.¹⁷
- Гадаад бодлогын шийдвэр гаргалтын нэн яаралтай шийдвэл зохих асуудлыг дээд удирдлага буюу засгийн газар нь салбар байгууллагуудад хувиарлах

¹⁶ Greg Cashman. “What Causes War?: An Introduction to Theories of International Conflict”. Lanham, Maryland: 2013. pp.80-82

¹⁷ Anthony G. McGrew, Michael John Wilson (ed), “Decision Making: Approaches and Analysis”. Manchester: Manchester University Press, 1982. pp.8-10

замаар шийдвэрлэдэг бол эдгээр салбар байгууллагууд нь өөрсдийн дэд нэгжүүдэд дахин хувиарлалт хийдэг. Олон түвшний төрөл бүрийн чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг эдгээр дэд хэсгүүд тус тусын арга барилд тулгуурлан судалгааг хийх ба судалгааны үр дүн, дүгнэлтүүдийг амжилттай нэгтгэх асуудал энэхүү загварын гол тулгамдсан асуудал болдог. Хэрэв энэхүү нэгтгэх үйл явц амжилтгүй болох аваас үр дагавар нь сөрөг гарна. Тиймээс дээд түвшний шийдвэр гаргагчаас өндөр түвшний менежерийн үр чадвар шаардагдах болно.

- Энэхүү загварын дагуу шийдвэр гаргах үйл явц нь байгууллагын хувьд доороосоо дээшээ хүртэл бүх шатандаа тогтсон стандартын дагуу буюу суурь эрх зүйн хэм хэмжээ, зарчмаар зохицуулагдаж харин бүх түвшний шийдвэр гаргалтад оролцож буй хувь хүмүүсийн зүгээс эрсдэл бага шаардагддаг тул илүүтэй нийтийн сэтгэл ханамжид суурилсан байдаг. Энэ нь хариуцлагын тогтолцоог сулруулах¹⁸ талтай байдаг.

Бюрократ бодлогын загвар¹⁹: “Засгийн газрын бодлогын загвар” аль эсвэл “Бюрократ бодлогын загвар” хэмээн нэрийддэг гадаад бодлогын шийдвэр гаргалтын энэхүү загвар нь Г.Эллисоны гурав дахь загвар юм. “Энэ загварын дагуу гадаад бодлогын шийдвэр нь оновчтой тоглогчийн болоод зохион байгуулалттай үйл явцын үр дүнгээр бус харин улс төрийн шийдвэр гаргалтын элит хэсгийн харилцаа, хамтын ажиллагааны үр дүнд гардаг”.²⁰ Өөрөөр хэлбэл улс төрийн эрх мэдэлд ойрхон байдаг, шийдвэр гаргалтад нөлөөлөх чадвартай элит хэмээн нэрийддэг хэсэг бүлэг хүмүүс өөрсдийн ашиг сонирхолыг хангах зорилгоор засгийн газартай байнга тохиролцоо хийж байдаг. Энэ нь гадаад бодлогын шийдвэр гаргалтад тодорхой нөлөө үзүүлж байдаг.

Г.Эллисоны “Шийдвэр гаргалтын мөн чанар” хэмээх бүтээлд онцолж буйгаар улс төрийн бодлогын шийдвэр нь бүхэлдээ засгийн газрын удирдах түвшний албан тушаалтан, эрх мэдэл бүхий этгээдүүдийн хоорондын улс төрийн яриа хэлэлцээний үр дүнгээс хамаардаг. Шийдвэр гаргалтын энэхүү загварын үндсэн оролцогчид болох засгийн газрын сайдууд, удирдлагын түвшний эрх мэдэлтнүүд өөр өөрсдийн яам, салбарынхаа ашиг сонирхолыг хангахын тулд удирдлагын түвшний бүхий л боломжит сувгийг ашигладаг. “Бюрократ бодлогын загвар”-ын дагуу шийдвэр гаргагчид шийдвэр гаргахдаа оновчтой зөв сонголтыг хийхээс илүүтэй “**өгөө аваатай байх**” зарчмыг баримталдаг байна.

“Бюрократ бодлогын загвар”-ыг тайлбарлахын өмнө бюрократ хэмээх үгийн үндсийг авч үзэх хэрэгтэй. Монгол хэлнээ энэ ойлголтыг хүнд суртал хэмээн орчуулан хэвшсэн, нэлээд сөргөөр ойлгогддог уламжлалтай. Бюро буюу франц

¹⁸ David A. Schultz. “Encyclopaedia of Public Administration and Public Policy”. New York: Infobase Publishing, 2009. p.175

¹⁹ Bureaucratic Politics model

²⁰ Sibaram Badatya. “Parliament and Foreign Policy Decision Making in India: A Study on India’s China Policy 1959-75”. PhD diss., Pondicherry University, 2015. p.44

хэлний “bureau” хэмээх үг нь “албан ажлын өрөө”, “ажлын ширээ” гэсэн утгыг илэрхийлнэ. Үгчлэн буулгаваас бюрократ гэдэг нь “албан ажлын өрөөний дүрэм журам”, эсвэл “албан ажлын ширээний засаглал” хэмээн ойлгогдоно.²¹ Өөрөөр хэлбэл монгол хэлэнд утгачлах аваас төрийн буюу нийтийн албаны засаглал гэж буух нь зүйтэй.

Орчин үеийн төр, улсын засаг захиргааны нарийн төвөгтэй, нүсэр бүтцийг харвал маш олон салбар нэгжүүд, тэдгээрт харъяалагддаг олон тооны албан тушаалтан, түшмэдийн нийлбэр юм. Эдгээр салбар нэгжүүд буюу яам, тамгын газрууд болон төрийн албаны удирдах түвшний хүмүүсийн нийтлэг зорилго бол тухайн улс гүрний нийтлэг ашиг сонирхолыг дээд түвшинд ханган ажиллахад орших ёстой. Энэ нь цаанаа шийдвэр гаргах дээд түвшний удирдлагын үйл ажиллагаанд тус дөхөм үзүүлэхэд чиглэгдэж байдаг.

Г.Эллисоны энэхүү гурав дахь загварын дагуу засгийн газар гэдэг нь бүхэл нэг бүтэц биш ба маш олон түвшний янз бүрийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэн явуулдаг салбар яамд, агентлаг, нэгж, байгууллага, албан тушаалтнуудаас бүрдсэн нэгдмэл нэг цогц ойлголт юм. Засгийн газрын бүтцэд багтаж буйн хувьд салбарын яам, тамгын газрууд болон албаны хүмүүс нь засгийн газрын бодлого боловсруулахад зөвшилцөх үүрэгтэй оролцохоос гадна бодлогын дүн шинжилгээ хийх, шийдвэр гаргахад тус дөхөм үзүүлж байх үүрэгтэй. Гэвч орчин үеийн улс төрийн салбарын маргаан мэтгэлцээнд бюрократ ба бюрократ бодлого гэдэг нь гол төлөв сөрөг утгаар ойлгогддог.²² Гадаад бодлогын шийдвэр гаргах асуудал дээр энэ байдал нь бүр ч тодорхой харагддаг.

Төрийн албаны гол гол албан тушаалд тохоон томилогдон ажиллаж буй сайд дарга нар хувийн ашиг сонирхолыг хангах, яам, байгууллагынхаа үйл ажиллагааны, зорилтыг хэрэгжүүлэхийн тулд өөр хоорондоо байнга өрсөлдөөнт нөхцөлд ажлаа явуулж байдаг. Эдгээр өндөр зэрэглэлийн албан тушаалтнууд нь төрийн дээд удирдлагын түвшинд гадаад бодлогын шийдвэр гаргахад ихээхэн үүрэг гүйцэтгэх боломжоор хангагдсан байдаг тул өөрсдийн яам, тамгын газрын зорилгыг хэрэгжүүлэхэд нэн түрүүнд анхааран ажилладаг. Жишээлбэл АНУ-ын гадаад бодлогын шийдвэр гаргах үйл явцад АНУ-ын Ерөнхийлөгч, түүний ажлын алба, Конгресс, Төрийн Департамент, Пентагон, Тагнуулын Төв Газар, Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөл гэх мэт олон тооны институт, тэдгээрийн удирдлагад ажиллаж буй өндөр зэрэглэлийн олон зуун албан тушаалтнууд чухал үүрэг гүйцэтгэж байдаг. Яам бүр өөрсдийн тодорхой үйл ажиллагааны чиглэл, зорилго зорилт, хэрэгжүүлэх арга ажиллагаатай. Засгийн газрын бүх л яам агентлагууд “*аль болох олон тооны ажил үүрэг гүйцэтгэх, бие даасан шийдвэр гаргах өргөн хүрээний эрх мэдэл, засгийн газрын бүтцэд томоохон байр эзлэх, нэр нөлөөтэй болох, хүн хүчний болон хүний болон материаллаг нөөц боломжийг хувьдаа бий*

²¹ Naidu, S.P. “Public Administration: Concepts and Theories”. New Delhi: New Age International. 2005. p. 80

²² Paul D’Anieri. “International Politics: Power and Purpose in Global Affairs”. Boston: Wadsworth, Cengage Learning, 2012. p.156

*болгон улмаар илүү их төсвийн мөнгө санхүүг захиран зарцуулах сонирхолтой байдаг”.*²³

Засгийн газрын яам, хэлтэс, газруудын эцсийн зорилго нь засгийн газрын бүтцэд голлох байр суурь эзэлж, шийдвэр гаргалтын давуу эрхтэй болоход оршдог. Эдгээр яам, агентлагийг төлөөлж буй албан тушаалтнууд нь чиглэл чиглэлээр үүрэг гүйцэтгэхдээ янз бүрийн мэдээллийн эх сурвалжид тулгуурлан, тус тусын арга барилын дагуу гадаад бодлогын тодорхой нэг асуудлыг тал талын байр сууринаас харж шийдвэрлэхийг зорьдог байна. Иймээс тэдгээрийн зорилгодоо хүрэх зам, гарах үр дүн нь харилцан адилгүй. Засаг захиргааны нэгж бүхэн өөрсдийн ашиг сонирхолыг ханган ажиллахыг урьтал болгодог бол удирдах албан тушаал хашиж буй этгээдүүд нь байгууллагынхаа (хувийн ашиг хонжоог ч мөн тооцож ажиллах тохиолдол гардаг) ашиг сонирхолыг засгийн газрын буюу үндэсний ашиг сонирхолтой зэрэгцүүлэх, заримдаа илүү үзэх явдал гардаг.²⁴

“Бюрократ бодлогын загвар”-аар шийдвэр гаргахад засгийн газрын бүтцийн ахлах албан тушаалтнууд (яамдын сайд, агентлагийн удирдах албаны хүмүүс) улс төрийн дээд түвшний шийдвэр гаргалтад туслалцаа дэмжлэг үзүүлэн, үйл ажиллагаагаа нийцүүлэн ажиллахаас илүүтэй өөр хоорондоо харилцан тохиролцох байдлаар өөрсдийн ашиг сонирхолыг хангах зарчмыг баримтладаг. Гадаад бодлогын шийдвэр гаргалтын үйл явцад нөлөөлөн оролцохдоо эдгээр ахлах албан тушаалтнууд яамдынхаа төдийгүй ихэнх тохиолдолд хувийнхаа ашиг хонжоог тооцдог. Үр дүнд нь шийдвэр гаргах үйл явц засгийн газрын бүтцийн байгууллагуудын хоорондын өрсөлдөөн, бие биенийгээ давах гэсэн үйл ажиллагаа болон хувирдаг. Грег Кэшмэний үзэж буйгаар энэхүү явцуурал нь салбар тус бүрийн байгууллагын онцлог, зан төлөвөөс шалтгаалдаг байна.²⁵

“Бюрократ бодлогын загвар” нь Г.Эллисоны “Шийдвэр гаргалтын мөн чанар”, АНУ-ын гадаад бодлогын нэрт судлаач, АНУ-ын ерөнхийлөгч асан Л.Жонсон, Р.Никсон, Б.Клинтон, Б.Обамагийн засаг захиргаанд ажиллаж байсан Мортон Хелпериний “Бюрократ бодлого ба гадаад бодлого”²⁶ хэмээх бүтээл, мөн энэ хоёр судлаачийн хамтын бүтээл болох “Бюрократ бодлого”-оор²⁷ дамжин олны хүртээл болсон билээ. Эдгээр судлаачид “бюрократ бодлогын загвар”-ыг гадаад бодлогын шийдвэр гаргалтад оролцож буй салбар бүрийн төлөөлөл ашиг сонирхолоо хангах зорилгоор өөр хоорондоо өрсөлдөж, эцэст нь харилцан тохиролцсоны үр дүнд шийдвэр гаргах үйл явц хэмээн тодорхойлсон байдаг. Г.Эллисон энэхүү загварын хүрээнд гадаад бодлогын шийдвэр гаргалтын найман хувилбарыг санал болгосон²⁸ бол Өмнөд Каролины Их Сургуулийн профессор Жерель Розати зөвхөн

²³ Greg Cashman. “What Causes War?: An Introduction to Theories of International Conflict”. Lanham, Maryland: 2013. p.90

²⁴ Ibid. pp.89-95

²⁵ Ibid. pp. 132-133

²⁶ Morton H. Halperin. “Bureaucratic Politics and Foreign Policy”. Washington, D.C.: Brookings, 1974. pp. 84-85

²⁷ Graham T Allison and Morton H. Halperin. “Bureaucratic Politics: A Paradigm and Some Policy Implications”. World Politics 24, Supplement 1972. pp. 40-79

²⁸ Graham Allison, Philip Zelikow. “Essence of Decision: Explaining the Cuban Missile Crisis”. Second Edition, New

дөрвөн хувилбарыг боловсруулсан байдаг.²⁹ Гэвч гадаад бодлогын чиглэлээр судалгаа хийдэг нэлээд судлаачид³⁰ “бюрократ бодлогын загвар”-ын нийтлэг талууд дээр үндэслэн үндсэн гурван хувилбарыг санал болгосон байна. Эдгээр нь “тогтвортой санал” буюу бодлогын шийдвэр гаргалтад түлхүү анхаардаг хувилбар, “наймаалцах санал” буюу шийдвэр гаргалтад оролцогчид өөрсдийн байр сууриа хамгаалахын тулд хэлэлцэн тохиролцоход илүү анхаардаг хувилбар, гурав дахь нь “үр дүнд хүрэх санал” буюу эцсийн дүндээ шийдвэр гарсан байх хувилбар юм.

Гадаад бодлогын шийдвэр гаргалтын энэхүү гурав дахь загвар буюу Г.Эллисоны “бюрократ бодлогын загвар” нь гадаад бодлогын шийдвэр гаргалтын онолын судалгааны шинэлэг, сонирхолтой загвар болсон юм. Байгууллагын онолын нэг хэсэг болохын хувьд энэ загвар нь улс төрийн “өгөө авааны” зарчимд суурилах нь элбэг. Хэдийгээр засгийн газрын байгууллагууд болон албан тушаалтнууд нь гадаад бодлогын судалгаа, дүн шинжилгээ, хэрэгжилтэд голлох үүрэгтэй ч шийдвэр гаргалтад эерэгээр нөлөөлөх магадлал бага юм. Үүний сацуу судлаачид энэ загварын дутагдалтай талуудыг дүгнэн бичсэнээс дөрвийг нь дараах байдлаар сийрүүлээ. Үүнд:

- Засгийн газрын салбарын удирдах албан тушаалтнууд ихэвчлэн байгууллагын аль эсвэл хувийн ашиг хонжоо гаргах тал дээр илүү анхаарч байдаг тул үндэсний ашиг сонирхол орхигдох талтай.
- Шийдвэр гаргалтын үйл явцад оролцож буй эдгээр албан тушаалтнууд өрсөлдөөнд ялах гэсэн хувийн сэтгэл зүйн байдлаасаа үүдээд үндэсний хэмжээний асуудал дээр буулт хийж нэгдсэн байр сууринд хүрэхдээ хойрго байдаг.
- Засгийн газрын салбар байгууллагууд бусдын дээр гарах гэсэн сэтгэхүйгээсээ болоод шаардлагагүй орон тоо, ажил үүргийг бий болгодогөөс үүдэн улсын төсвийн ихээхэн хэмжээний мөнгө, санхүүг дэмий үрэн таран хийх магадлал өндөр.
- Удирдах албан тушаалтнуудын дунд ажилдаа мэргэшсэн байдлаар хандах хандлага түгээмэл ажиглагддаг. Энэ нь хэдийгээр байгууллагын үнэт зүйл, уламжлалыг хадгалахад сайн талтай ч шинэ санаа, шинэлэг арга барилаар асуудалд хандах хандлага төлөвшүүлэхэд сөрөг нөлөө үзүүлдэг. Тийм учир бодлогын шийдвэр гаргалт уламжлалт арга барилд тулгуурлахаас биш бүтээлч байдал үгүйлэгддэг жамтай.

“Бюрократ бодлогын загвар” нь шийдвэр гаргалтын олон янзын хувилбарыг боловсруулах боломжтой ч яаралтай шийдвэр гаргах, ялангуяа хямралын үед

York: Longman, 1999. pp.182-183

²⁹ Jerel A. Rosati. “Developing a Systematic Decision-Making Framework: Bureaucratic Politics in Perspective”. World Politics 33, no. 3, 1981. pp.234-252

³⁰ Тухайлбал: Klaus Brummer (2009), Richard Stillman (1990), Thomas Preston (1999), Paul ‘t Hart (2012), David R. Berman (1985)

шийдвэр гаргахад үр дүнтэй загвар болж чадахгүй. Г.Эллисоны нотолсоноор албан тушаалтнуудын хоорондын өрсөлдөөн, наймаа, тохиролцоо нь оновчтой шийдвэр гарах магадлалыг багасгадаг бөгөөд эцсийн дүндээ талуудын харилцан буулт нь үндэсний ашиг сонирхолтой зөрчилдөх нь элбэг тохиолдоно. Хэдий тийм боловч жирийн үед, яаралтай шийдвэр гаргах тулгамдсан асуудал үүсээгүй тохиолдолд энэхүү гурав дахь загвар нь зөв хэрэгжүүлбэл үр дүн өндөр байх боломжтой юм.

ДҮГНЭЛТ

Улс үндэстний эрх ашигт нийцсэн эцсийн бөгөөд оновчтой шийдвэр гаргана гэдэг нь тусгаар тогтносон бүрэн эрхт улсын хувьд маш чухал зүйл юм. Гадаад бодлогын шийдвэр гаргах үйл явц нь гадаад хүчин зүйл буюу олон улсын дэг журам ба цаг үеийн нөхцөл байдал, дотоод хүчин зүйлс буюу улс төр, нийгэм-эдийн засгийн тогтолцоо, үндэстний онцлог, шийдвэр гаргалтад нөлөөлөх гэсэн тодорхой оролцогчдын үйл ажиллагаа, шийдвэр гаргагчийн хувь зан чанар гэх мэт маш олон хүчин зүйлээс шалтгаалдаг тул зөв шийдвэр гаргана гэдэг ихээхэн төвөгтэй үйл явц юм. Энэ асуудлыг үр дүнтэйгээр шийдэх зорилгоор эрдэмтэн Г.Эллисон гадаад бодлогын шийдвэр гаргалтын онолын гурван загварыг АНУ-ын жишээн дээр боловсруулсан нь өнөөдөр олон орны судлаач эрдэмтэд, шийдвэр гаргагчдын үйл ажиллагаандаа баримталдаг загвар болсон байна.

Г.Эллисоны эхний загвар буюу **“оновчтой тоглогчийн загвар”**-ын дагуу шийдвэр гаргагч нь логик сайтай дүгнэлт сэлтэд үндэслэн оновчтой шийдлийг сонгон шийдвэр гаргах бөгөөд энэ загвар нь нэн яаралтай шийдвэр гаргах шаардлагатай хямралт байдлын үед ихээхэн зохимжтой.

Хоёр дахь загвар буюу **“Зохион байгууллалттай үйл явцын загвар”** нь тогтсон стандарт, зохион байгуулалт бүхий үйл ажиллагааны үр дүнд шийдвэр гардаг. Энэхүү загварын хувьд шийдвэр гаргах механизмын бүтэц нь мэргэшсэн олон тооны салбар, дэд хэсгүүдээс бүрдэх ба эдгээр салбар нэгжүүд нь үүрэг хариуцлагынхаа хүрээнд шийдвэр гаргах үйл явцад тус тусын хувь нэмрийг оруулах замаар шийдвэр гардаг уламжлалтай. Өөрөөр хэлбэл засгийн газрын бүтцэд багтаж буй яам, агентлагууд нь өөрсдийн эрх мэдлийн хэмжээнд асуудлыг боловсруулан шийдвэр гаргагч дээд түвшний удирдлагад хүргүүлдэг бол удирдлагын түвшний шийдвэр гаргагч нь доороос ирсэн дүгнэлтүүдийг нэгтгэн зангидаж, эцсийн шийдвэрийг гаргадаг.

Харин **“Бюрократ бодлогын загвар”** нь засгийн газрын удирдах түвшний голлох албан тушаалтнуудын санал зөрөлдөөнийг эцэслэх замаар хугацаа шаардсан, нэлээд ярвигтай үйл ажиллагааны үр дүнд шийдвэр гардаг онцлогтой. Эхний хоёр загвараас ялгаатай нь “бюрократ бодлогын загвар” нь оновчтой, логик гаргалгаа сайтай дүгнэлт, тогтсон зохион байгуулалт бүхий үйл ажиллагаанд тулгуурлахаас илүүтэй тухайн асуудлаарх нэгдсэн шийдлийг (консенсус) эцсийн

шийдвэр гаргалтын үндэс болгодог байна. Г.Эллисоны гурав дахь загварын дагуу шийдвэр гаргах механизм нь шийдвэр гаргалтад илүү их эрх мэдэл эдлэх гэсэн, гарсан шийдвэрээс ихээхэн ашиг хонжоо олох гэсэн тодорхой тооны байгууллага, албан тушаалтнуудаас бүрддэг. Энэхүү албан тушаалтнуудын хоорондын яриа хэлэлцээ, тохиролцооны үр дүн нь тодорхой нэгдмэл байр сууриар бус дундын хувилбар, харилцан буултаар тодорхойлогддог. Маш оновчтой зөв шийдвэр гарах магадлал энэ загварын хувьд тун бага байдаг онцлогтой ба улс төрийн бодлогын үр дагавар ч тааруу байх магадлал өндөр юм.

Хэдийгээр Г.Эллисоны гурван загвар онолын хувьд хамгийн сайн боловсруулагдсан гэж онолын судлаачид, практик шийдвэр гаргагчид үздэг ч дээрх 3 загварын хувьд гадаад бодлогын шийдвэр гаргах үйл явц нь адилхан олон түвшний, олон хэмжээс бүхий үйл ажиллагаа юм. Гадаад бодлогын шийдвэр гаргалтын нарийн төвөгтэй үйл ажиллагаа нь асуудлыг тодорхойлох, асуудлын учир шалтгааныг олж илрүүлэх, асуудлыг шийдвэрлэх олон хувилбаруудыг боловсруулах, зөв хувилбарыг сонгон шийдвэр гаргах зэрэг хэд хэдэн шатлалаас бүрдэнэ. Шатлал тус бүрт асуудалд нөлөөлж буй хүчин зүйлийг тодорхойлж эрсдэлийн үнэлгээг хийн, шийдэлд хүрэх олон янзын хувилбарыг шүүн тунгааж эцсийн шийдвэрийг гаргах шаардлагатай. Мөн шийдвэр гаргах үйл явцын эцсийн үр дүн нь удирдагчийн зан чанар, улс төрийн тогтолцоо, нийгэм соёлын онцлог, цэрэг эдийн засгийн хүч чадавх, газарзүйн нөхцөл байдал, олон улсын харилцааны систем зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалан янз бүр байдаг. Иймээс гадаад бодлогын шийдвэр гаргалтад нөлөөлдөг эдгээр хүчийн зүйлийн нөлөөллийг бууруулан, улмаар эрсдлийг зөв тооцоолж, тодорхой нөхцөлд аль загвар нь оновчтой байх вэ гэдгийг шинжлэх ухааны үндэслэл, нотолгоо сайтай судалгааны ажлын үр дүнгээр тодорхойлох нь зайлшгүй хийгдэх ёстой ажил юм.

Монгол улсын хувьд өнөөгийн байдлаар гадаад бодлогын шийдвэр гаргах үйл явцад Г.Эллисоны гурван загвараас гурав дахь загвар буюу “бюрократ бодлогын загвар” давамгайлж байна хэмээн дүгнэж болно. Учир нь Монголын улс төрийн шийдвэр гаргах элит хэсгийг бүрдүүлж буй улс төрийн намууд, тэр дундаа бизнес эдийн засгийн бүлэглэлүүд нь өөр өөрсдийн эрх ашигт нийцсэн шийдвэрийг гаргахаар өрсөлдөж байдаг. Энэхүү өрсөлдөөний үр дүнд Монгол улсын улс төр, эдийн засгийн бодлогын шийдвэр гарч буйг харж болно. Харамсалтай нь шийдвэр гаргалтын энэ загвар нь үндэсний ашиг сонирхолд нийцсэн бус бүлэглэлүүдийн эрх ашигт ницсэн шийдвэр гаргахад тохиромжтой тул Монгол улсын хувьд төдий л оновчтой загвар биш болох нь харагдаж байна.

Харин доктор, профессор Г.Төмөрчулуун 2016 онд хэвлүүлсэн “Монголын гадаад бодлого: XX, XXI зууны зааг дээр” хэмээх бүтээлдээ: “Бага, тэгэхдээ ардчилсан улс төрийн системтэй улсуудын хувьд ихэнх тохиолдолд зохион байгуулалтын гэж нэрлэгдэх хоёр дахь хувилбар өргөн хэрэглэгддэг болно. Гэхдээ бусад хувилбар Монголын нөхцөлд таарахгүй гэж хэлж байгаа зүйл хэрхэвч биш бөгөөд ардчилалын үйл явц гүнзгийрэх тусам эдгээр хувилбаруудын ач холбогдол

нэмэгдэнэ”³¹ хэмээн дурьдсанчлан Монгол улсын гадаад бодлогын тулгамдаж буй асуудал болох нэгдмэл байдал, залгамж чанар хадгалагдах асуудлыг шийдвэрлэхэд Г.Эллисоны хоёр дахь загвар болох “Зохион байгууллалттай үйл явцын загвар” илүү тохиромжтой байх магадлал өндөр байна.

НОМ ЗҮЙ

- Төмөрчулуун.Г. “Монголын гадаад бодлого: XX, XXI зууны зааг дээр”. Мөнхийн үсэг. УБ., 2016.
- Alex Mintz and Karl DeRouen. “Understanding Foreign Policy Decision Making”. New York: Cambridge University Press, 2010.
- Anthony G. McGrew, Michael John Wilson (ed), “Decision Making: Approaches and Analysis”. Manchester: Manchester University Press, 1982.
- David A. Schultz. “Encyclopaedia of Public Administration and Public Policy”. New York: Infobase Publishing, 2009.
- Graham Allison, Philip Zelikow. “Essence of Decision: Explaining the Cuban Missile Crisis”. Second Edition, New York: Longman, 1999.
- Graham T Allison and Morton H. Halperin. “Bureaucratic Politics: A Paradigm and Some Policy Implications”. World Politics 24, Supplement 1972.
- Greg Cashman. “What Causes War? An Introduction to the International Conflict”. Lanham, Maryland: Lexington Books, 2000.
- Janice Gross Stein. “Foreign Policy Decision-Making: Rational, Psychological, and Neurological Models”, in Foreign Policy: Theories, Actors, Cases”. Edited by Steve Smith, Amelia Hadfield and Tim Dunne. Oxford: Oxford University Press, 2008.
- Jerel A. Rosati. “Developing a Systematic Decision-Making Framework: Bureaucratic Politics in Perspective”. World Politics 33, no. 3, 1981.
- Martin Hollis and Steve Smith. “Explaining and Understanding International Relations”. Oxford: Clarendon Press, 1990.
- Morton H. Halperin. “Bureaucratic Politics and Foreign Policy”. Washington, D.C.: Brookings, 1974.
- Naidu. S.P. “Public Administration: Concepts and Theories”. New Delhi: New Age International. 2005.
- Paul D’Anieri. “International Politics: Power and Purpose in Global Affairs”. Boston: Wadsworth, Cengage Learning, 2012.
- W. Raymond Duncan, Barbara Jancar-Webster, Bob Switky, World Politics in the 21st Century (Boston: Cengage Learning, 2009)
- J. Renshon, S.A. Renshon. “The Theory and Practice of Foreign Policy Decision Making”. Political Psychology, Vol. 29 No. 4, 2008.
- Sibaram Badatya, “Parliament and Foreign Policy Decision Making in India: A Study on India’s China Policy 1959-75” (PhD diss., Pondicherry University, 2015)
- Efe Yegul, “US Foreign Policy Decision Making Process and Key Actors” University of Warsaw paper, https://www.academia.edu/36624180/US_Foreign_Policy_Decision-Making_Process_and_Key_Actors

³¹ Төмөрчулуун.Г. “Монголын гадаад бодлого: XX, XXI зууны зааг дээр”. Мөнхийн үсэг. УБ., 2016. 30-31 дэх тал.

